| 2.20 | Арга хэмжээ 2.20<br>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих | - | Хурлын тоо, Хөрөнгийн үнийн дүн, сая төгрөг | 12<br>Бүртгэх хөрөнгө 3,211.0,<br>Хасах хөрөнгө 25,501.6,<br>Балансаас балансt шилүүлэх хөрөнгө 30,058.3,<br>Дахин үнэлсэн хөрөнгө 5,729.9,<br>Данснаас дансанд шилжүүлсэн хөрөнгө 12,291.9 | 24<br>Хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцэж шийдвэрийг нийслэлийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн байна. | ҮХХХК-ийн 12 удаагийн хурал зохион байгуулан нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой давхардсан тоогоор **692** байгууллагын **96,505.89** сая төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:<br>- *Давхардсан тоогоор 124 байгууллагын 7,357.08 сая төгрөгийн үнэ бүхий гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүдээс хандивласан, төсөл хөтөлбөрөөр бий болсон тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэх мэт хөрөнгийг бүртгэх,*<br>- *Давхардсан тоогоо 289 байгууллагын 31,730.62 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг акталж нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах,*<br>- *Давхардсан тоогоор 154 байгууллагад 32,422.04 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх,*<br>- *Нийт 154 байгууллагын элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах 24,107.77 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэх,*<br>- *Нийт 15 байгууллагын 888.38 сая төгрөгийн хөрөнгө данснаас дансанд шилжүүлэх.* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.21 | Арга хэмжээ 2.21<br>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь хөрөнгийн хөдөлгөөнийг мэдээллийн санд баталгаажуулах, нэгтгэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Үндэсний статистикийн хороонд ТӨ болон ТӨХ маягтуудын дагуу мэдээллийг хүргүүлэх | - | Хуулийн этгээд, сангийн тоо, Мэдээллийн сан дахь нийслэлийн өмчийн хөрөнгийн дүн, сая төг | Хуулийн этгээд 877<br>Сан 45<br><br>7.6 их наяд | Хуулийн этгээд 877<br>Сан 45<br><br>- | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.04.16-ны өдрийн А-1/741 дүгээр албан бичгийн дагуу нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, төрийн өмчийн бүртгэлийн "ТӨХ" болон захиргааны статистикийн "ТӨ" маягт тайлангуудын нэгтгэлийг Төрийн өмчийн цахим системээр хүлээн авах, дүнг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр Сангийн яамны "э-тайлан" цахим системтэй тулган баталгаажуулсан.<br><br>Нэгтгэлд нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой нийт 889 хуулийн этгээд, 44 данс сангийн мэдээлэл хамрагдсан бөгөөд нийт хөрөнгийн дүн **11.2 их наяд** төгрөгөөр бүртгэгдэн 2023 онтой харьцуулахад 68.67 хувиар нийслэлийн өмч нэмэгдсэн байна. Мэдээллийн сан дах балансын хөрөнгийн задаргааг харуулбал:<br><br>1. Эргэлтийн хөрөнгийн дүн - 6,004.6 тэрбум төгрөг<br>2. Эргэлтийн бус хөрөнгө - 5,166.2 тэрбум төгрөг, үүнээс:<br>- *Барилга, байгууламж - 2,877.6 тэрбум төгрөг*<br>- *Машин тоног төхөөрөмж - 799.9 тэрбум төгрөг*<br>- *Тээврийн хэрэгсэл – 482.3 тэрбум төгрөг*<br>- *Тавилга, эд хогшил - 164.0 тэрбум төгрөг*<br>- *Биет бус хөрөнгө 1,323.7 тэрбум төгрөг*<br>- *Тайлант үеийн ашиг алдагдал 134,3 тэрбум төгрөг* | 100 |
| 2.22 | Арга хэмжээ 2.22<br>Нийслэлийн өмчөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолын дагуу төсвийн орлогын нэр төрөл бүрээр хангаж ажиллах | | Орлогын дүн, сая төгрөг, Хэрэгжилтийн хувь | 7,492.6<br>118% | 6,752.7<br>100% | Нийслэлийн Өмчийн харилцааны газраас нийслэлийн төсвийн орлогын хуваарийн дагуу түрээсийн орлого 3,068.9, ангилагдаагүй бусад орлого 150.0 сая , аж ахуй нэгжийн ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 1,533.8 сая төгрөг, гүйцэтгэл өссөн дүнгээр 2025.11.30-ны өдрийн байдлаар **7,178.6** сая төгрөг төвлөрүүлж **106** хувийн хэрэгжилттэй ажилласан. Төсвийн орлогыг нэр төрөл бүрээр нь ангилан харуулбал:<br>- *Түрээсийн орлогын төлөвлөгөө 2,800.0 сая төгрөг, биелэлт 1,800.2 сая төгрөг,*<br>- *Ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 1,342.0 сая төгрөг, биелэлт 1,286.8 сая төгрөг,* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *Актлагдсан хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө 125.0 сая төгрөг, биелэлт 207.7 сая төгрөг,*<br>- *Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөө 2,000.0 сая төгрөг, биелэлт 3,904.4 сая төгрөг.* | |
| 2.23 | Арга хэмжээ 2.23<br>Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн өмчит хуулийн этгээдийн данснаас хассан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах | - | Тээврийн хэрэгслийн тоо<br><br>Дүн, сая төгрөг | 62<br><br>294.0 | Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Нийслэлийн төсөвт 14 байгууллагын 60 тээврийн хэрэгсэл данснаас хасах хүсэлтийг судалж НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-ын дагуу баримтыг бүрдүүлэн өргөн барьж Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/645 дугаар “Тээврийн хэрэгсэл данснаас хасах тухай” захирамжаар шийдвэрлүүлсэн.<br><br>Нээлтэй дуудлага худалдаагаар худалдах тээврийн хэрэгслүүдийг судлахад:<br>- *Үзлэг, оношилгоонд хамрагдаагүй 29 тээврийн хэрэгсэл,*<br>- *Авто тээврийн үндэсний төвийн цахим бүртгэлд бүртгэлгүй 5 тээврийн хэрэгсэл,*<br>- *Нийт 6 тээврийн хэрэгсэл 1,563,714 төгрөгийн татварын өртэй,*<br>- *Нийт 15 тээврийн хэрэгсэл 2,367,800 торгууль төлөөгүй,*<br>- *Бүртгэл болон татвар, торгуулийн зөрчилгүй 2 тээврийн хэрэгсэл байна.*<br><br>Тээврийн хэрэгсэл данснаас хасах захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох журмын дагуу тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээллийг байгууллагын https://www.umch.ub.gov.mn/news/show/teevrijnheregslijn-neelttej-duudlagyn-hudaldaand-urzh-bajna/mn сайт, өдөр тутмын сонинд зар мэдээлэл байршуулан 2025.07.28 өдөр зохион байгуулсан. Тус дуудлагын худалдаанд нийт давхардсан тоогоор 46 оролцогч оролцож **21** тээврийн хэрэгслийг 61,506,000 **(61.5 сая)** төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. | 100 |
| 2.24 | Арга хэмжээ 2.24<br>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн акталж данснаас хассан тээврийн хэрэгсэл, | - | Дүн, сая төгрөг | 262.8<br>100% | Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлэх, | НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжаар данснаас хассан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бусад хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлэх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | | худалдан борлуулах шийдвэрийн хэрэгжилтийг 100% хангасан байна. | тээврийн хэрэгсэл, НӨХГ-ын даргын **274** тушаалаар данснаас хассан тавилга, тоног төхөөрөмжийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн худалдан борлуулах ажлыг зохион байгуулж 2025.12.03-ны өдрийн байдлаар хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан хөрөнгийн орлого нийт **205.0 сая** төгрөгийг нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн. | |
| 2.25 | Арга хэмжээ 2.25<br>Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох | - | Шүүхийн маргааны тоо,<br>Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо | 3<br>0 | 3<br>- | Шүүхийн хянан шийдвэрлэгдэх ажиллагаанд НИТХ, НЗД-ыг төлөөлөн 4 маргаанд итгэмжлэгчээр оролцож байна. Үүнд:<br><br>1. *Нэхэмжлэгч: "Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв " ХХК,*<br>*Хариуцагч: НИТХ, НЗД, НӨХК*<br>*Нэхэмжлэлийн шаардлага: НИТХ-ын 2025 оны 25/35 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах, ЗХАШШ 20 дугаар шүүхийн 2014 оны 620 дугаар шийдвэрийг биелүүлэхгүй байгаа НӨХК-ийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, НИТХ-ын 2025 оны 25/77 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах, НЗД-ын 2025 оны А/84 дугаар захирамжийг хүчингүй болгуулах;*<br>*Явц: Шүүх хурал 3 удаа хойшилсон. Дараагийн хурал 2025.12.08-ны өдрийн 10 цагт товлогдсон.*<br><br>2. *Нэхэмжлэгч: "Наранбулаг сервис" ХХК, "Бадрал" ХХК,*<br>*Хариуцагч: НИТХ, НЗД, НӨХГ*<br>*Нэхэмжлэлийн шаардлага: НИТХ-ын 2025 25/101 дугаар тогтоол илт хууль бус болохыг тогтоолгох,ЧД-ийн 5 дугаар хороонд байрлах Баруун Сэлбэ үйлчилгээний төвийн "Нарны титэм" барилгын Ж блокын 175 м.кв, 155 м.кв талбай бүхий хэсгийг Монгол Улсын Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д заасан нөхцөлөөр "Наранбулаг сервис" ХХК, "Бадрал" ХХК-д тус тус хувьчлах асуудлыг шийдвэрлэсэн хүчин төгөлдөр хэвээр байгаа НИТХ-ын 2018.12.05-ны өдрийн 20/21 тоот тогтоолыг хэрэгжүүлэхгүй байгаа НЗД-ын эс үйлдэхүйг хууль бус" болохыг тогтоолгох, хүчин төгөлдөр хэвээр байгаа НИТХ-ын 2018.12.05-ны өдрийн 20/21 тоот тогтоолыг хэрэгжүүлж, "Наранбулаг сервис" ХХК, "Бадрал" ХХК-д тус* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *тус хувьчлахыг НИТХ-д бодит, үнэн зөвөөр танилцуулж, шийдвэрлүүлэхийг НЗД-д даалгах*<br>*Явц: 2025.10.29-нд шүүх хурал болж хариуцагчийн зүгээс "Ажбогд" ХХК-ийг гуравдагчаар оролцуулах хүсэлт гаргасан. Шүүх хүлээн авснаар дараагийн хурлыг 2025.12.09-ний өдөр 13:30-д товлогдсон.*<br><br>3. *Нэхэмжлэгч: С.Пүрэвжав, С.Мягмарсүрэн, Хариуцагч: НӨХГ, НЗД, НӨХК*<br>*Нэхэмжлэлийн шаардлага: НӨХК-ийн 2024 оны 02 дугаар Өмчлөгчийн эрх олгох тухай тогтоолыг хүчингүй болгуулах, өмчлөгчийн эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах*<br>*Явц: Шүүх хурал товлогдоогүй байна.*<br><br>4. *Нэхэмжлэгч: "Лхатоном" ХХК,*<br>*Хариуцагч: НИТХ, НӨХГ*<br>*Нэхэмжлэлийн шаардлага: НИТХ-ын 2025 оны 25/58 тогтоолыг хүчингүй болгуулах.*<br>*Явц: Шүүх хурал 2 удаа хойшилсон. Одоогоор товлогдоогүй байна.* | |
| 2.26 | Арга хэмжээ 2.26<br>Нийслэлийн өмчид хохирол учруулсан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан, гэрээний заалтыг зөрчсөн зэрэг өмч хөрөнгийн холбогдолтой асуудлыг хяналт шалгалтын байгууллагаар шийдвэрлүүлэх, шүүхийн маргаанд нэхэмжлэгчээр оролцох, | - | Хөрөнгийн маргааны тоо,<br>Дүн, сая төг | 16<br>2,046.5 | 15<br>1,922.2 | НӨХГ-ын газрын балансад бүртгэлтэй 15 объектын өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, хууль бус байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар НПГ-т өргөдөл, гомдлыг гаргасан дараах асуудлуудыг авлигын эсрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байдлыг шалгуулахаар АТГ-д шилжүүлсэн байна. Үүнд:<br>1.Прокурорын тогтоолоор хэрэг бүртгэлтийн **6** хэргийг хаасан байна. Үүнд:<br>1) *МБШҮТ-ийн тэргүүн С.Санждорж нь СБД, 18 хороо, Дамбадаржаа хийдийн Цогчин дуганы барилгыг чөлөөлж, хүлээлгэн өгөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд хэрэг бүртгэлтийн 240200420 дугаартай хэргийг НПГ-ын 2024.12.20-ны өдрийн Д392 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2. дахь заалтад заасан "гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан" үндэслэлээр;* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2) *НЗДТГ, НӨХГ-ын эрх бүхий албан тушаалтнууд нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Москва рестораны баруун талд байрлах Шуудангийн 24 дүгээр салбарын 198 м.кв бүхий үйлчилгээний зориулалттай барилга дээр 2 давхар барилгыг нэмж барих зөвшөөрлийг олгож бусдад давуу байдал бий болгосон байж болзошгүй гэх хэрэгт хэрэг бүртгэлтийн 240200428 дугаартай хэргийг НПГ-ын 2025.06.25-ны өдрийн Д209 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр;*<br>3) *ХУД, 3 хороо “Монгол шуудан” ХК-ийн 36 дугаар салбарын байрыг НӨХГ-ын балансаас шийдвэргүйгээр хасагдуулсныг холбогдох хууль, журам зөрчсөн байдалд хэрэг бүртгэлтийн 240200421 дугаартай хэргийг НПГ-ын 2025.01.20-ны өдрийн Д19 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр;*<br>4) *БГД, 7 хороо, “Эрхэм жаргалан” ӨЭМТ-ийн хуучин барилга болон БГД, 14-р хороо Москва рестораны баруун талд байрлах объектыг “Тэмүүжин групп” ХХК-д эзэмшүүлж, ашиглуулсан, давхар түрээслэж ашиг олсон үйлдэлд хэрэг бүртгэлтийн 240200423 дугаартай хэргийг НПГ-ын 2025.01.27-ны өдрийн Д24 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр;*<br>5) *СБД, 2 хороо, 1а байрны 1 тоот байрыг “Ачит гар” ӨЭМТ хийц бүтээцийг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байр чөлөөлөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд АТГ-ын 240200443 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурорын 2025.02.07-ны өдрийн Д34 тогтоолоор “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр;*<br>6) *ЧД, Жигжиджавын барилгад “МУНУХ" ТББ гэрээгүйгээр үйл ажиллагаа явуулдаг асуудалд АТГ 240200427 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурорын 2025.02.07-ны өдрийн Д36 тогтоолоор “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр;* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа **8** хэрэгт:<br>1) *ХУД, 22 хороо, Ар зайсангийн гудамж-1 (Зайсангийн аманд) байрлах барилга, эзэмшил газрыг УАУЭСКТ-ийн Ж.Хатанбаатарт менежментийн гэрээгээр хувьчлахаар гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулсан асуудалд;*<br>2) *БГД, 8 хороо, "Аминжаргалан" ӨЭМТ-ийн хуучин барилгыг Иргэн Б.Ганцогт бусдад дамжуулан Чин Гэгээн өргөө ӨЭМТ-д түрээслсэн асуудалд;*<br>3) *БГД, 14 хороо, Москва рестораны баруун талд, түрээсийн гэрээтэй, "Тэмүүжин майнинг групп" ХХК түрээсийн гэрээ байгуулан, үйл ажиллагаа явуулдаг байсан асуудалд;*<br>4) *ХУД, 22 хороо, ЗДТГ-ын балансt бүртгэлтэй, Богд уулын аманд байрлах байр, ХУД, 4-р хороо, НТЗ-ны Яармагийн шинэ цогцолборт "Их үйлсийн хишиг" ХХК-тэй байгуулсан 2023 оны түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу хийгээгүй асуудалд;*<br>5) *СХД, 20 хороо, Хүнсчдийн гудамжны 3А, Орбитын орон сууцны дунд байрлах 1 давхар барилга, эзэмшил газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ иргэн С.Батчулууны нэр дээр гарсан асуудалд;*<br>6) *СХД, 14 хороо, 1-р хороолол, 14-8-253 тоотод иргэн О.Сүрэнхорлоо ҮХЭХӨУБ-ийн Ү-2201020811 гэрчилгээ гарсан асуудалд;*<br>7) *БГД, 14 хороо, 3 хорооллын 18-30, иргэн П.Цогтбаатар ҮХЭХӨУБ-ийн Ү-2205082124 гэрчилгээ гарсан асуудалд;*<br>8) *СБД, 6 хороо, Эмийн үйлдвэрийн барилгын газрыг УАУЭСКТ-д "орон сууц, үйлчилгээ"-ний зориулалтаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлсэн асуудалд;* | |
| 2.27 | Арга хэмжээ 2.27<br>Өмчийн харилцааны зөрчил маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагад хянан шийдвэрлэхэд төлөөлөн оролцох, шүүхэд тайлбар, холбогдох нотлох баримт гаргаж өгөх, мэдээ тайлан гаргах | - | Шүүхийн маргааны тоо,<br>Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо | 2<br>- | 2<br>- | Хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа **4** хэрэгт нэхэмжлэгчээр, **2** хэрэгт хариуцагчаар оролцож байна. Үүнд:<br>1) *Нэхэмжлэгч: НӨХГ,*<br>*Хариуцагч: иргэн Б.Ганцогт*<br>*Шүүх хурал ХУД-ийн ИХАШТШ-ийн 2025. 09.18-ны өдрийн Д192/ШШ2025/07349 шийдвэрээр хариуцагчаас* ***9,338,395.0*** *төгрөгийг нэхэмжлэгчид гаргуулахаар шийдвэрлэсэн. НДИХДЗШШ-ийн хурал 2025.11.17-ны өдөр болж ХУД-ийн ИХАШШТШ-ийн 2025.09.18-ны өдрийн Д192/ШШ2025/07349* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *дугаар шийдвэрийг хэвээр үлдээсэн. Шүүхийн магадлал ирээгүй байна.*<br>2) *Нэхэмжлэгч: НӨХГ,*<br>*Хариуцагч: "Ачит гар" ӨЭМТ*<br>*Нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзах хүсэлт гаргасан.*<br>3) *Нэхэмжлэгч: НӨХГ,*<br>*Хариуцагч: иргэн Г.Алтантуяа*<br>*Түрээслэгч иргэн Г.Алтантуяа нь 2024 онд НӨХГ-тай байгуулсан Түрээсийн гэрээний төлбөр болох* ***5,588,100.0*** *төгрөгийн төлөөгүй түрээсийн үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг БЗД, СБД, ЧД-ийн ИХАШТШ-д гаргасан.*<br>4) *Нэхэмжлэгч: НӨХГ,*<br>*Хариуцагч:"Хоёр сайхан хайрхан" ХХК*<br>*НӨХГ-тай 2024 онд түрээсийн гэрээ байгуулсан "Хоёр сайхан хайрхан" ХХК нь 1,026,000.0 төгрөгийн түрээсийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн тул БЗД, СБД, ЧД-ийн ИХАШТ-д нэхэмжлэл гаргасан.*<br>5) *Нэхэмжлэгч: "Материал Импекс" ХК,*<br>*Хариуцагч: НӨХГ*<br>*Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. 2025.11.24-ны өдрийн шүүх хурал хойшилсон. Тов зарлагдаагүй байна.*<br>6) *Нэхэмжлэгч: "Улаанбаатар Радио" ХХК,*<br>*Хариуцагч: НӨХГ*<br>*2024.12.13-ны өдөр иргэний хэрэг үүсэж, 2025.05.22-ны өдөр нэхэмжлэгч "Улаанбаатар Радио" ХХК-ийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан хүсэлтийн дагуу шүүх 2025.09.09-ний өдрийн 191/ШШ2025/05246 дугаар захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгосон.* | |
| 2.28 | Арга хэмжээ 2.28<br>Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Х.Батчимэг, прокурор Б.Болортуяа нартай уулзалт хийж, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдээс үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх, шүүхэд үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргах ажлуудыг шат дараалан хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллан, төр нийтийн ашиг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сонирхлыг хамгаалж өгөхийг хүссэн 1/765 дугаар албан бичгийг 2025.05.13-ны өдөр хүргүүлэн ажилласан. Энэхүү ажлын үр дүнд нийслэлийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх ач холбогдолтой юм.<br>Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн прокурор Я.Болортуяа НӨХГ-ын нэхэмжлэлтэй, иргэн Б.Ганцогтод холбогдох иргэний хэрэгт бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон.. | |
| 2.29 | Арга хэмжээ 2.29<br>Холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал оруулах, өмчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг сурталчлан, арга зүйгээр хангах | - | Саналын тоо Хэрэгжилтийн хувь | "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" -т 4 арга хэмжээ, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд тусган 3 арга хэмжээ, хуулийн төсөл 1 | 100% | НЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу дараах хууль, дүрэм журмын төсөлд санал хүргүүлсэн. Үүнд:<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,*<br>- *Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам,*<br>- *Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хууль*<br>- *Худалдан авах ажиллагааны тухай хууль*<br>- *Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль*<br>- *Арилжааны тухай хууль*<br>- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль*<br>- *Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль*<br>- *Нийтийн өмчийн тухай хууль,*<br>- *Дулаан хангамжийн тухай хууль*<br>- *"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн төсөл*<br>- *"Эдийн засгийн эрх чөлөөний тухай" хууль,*<br>- *"Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай" анхдагч хууль,*<br>- *Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга,*<br>- *Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн төсөл.* | 100 |
| 2.30 | Арга хэмжээ 2.30<br>НИТХ-ын тогтоол, нийслэлийн Засаг даргын | - | Үйл ажиллагааны | 100% | 100% | Нийтийн өмчийн тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдан, хүчин төгөлдөр болсноор НИТХТ-ийн 2014 онд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | захирамжаар батлагдан нийслэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа нийслэлийн өмчийн эрх зүйн акт, дүрэм, тогтоол, журмуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | | хэрэгжилтийн хувь | | | батлагдсан, нийслэлийн өмчийн хөрөнгөтэй холбоотой журмуудыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Үүнд:<br>- *НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам", "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам", "Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам",*<br>- *НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар",*<br>- *НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам", Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ", "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ",*<br>- *НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам",*<br>- *НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийг хувьчлах журам","Нийслэлийн өмч хувьчлах комиссын ажиллах журам",*<br>- *НИТХТ-ийн 2014 оны 68 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам".*<br><br>Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 6 үйлдвэрийн газрын дүрмийн төсөлд санал оруулан тухайн үйлдвэрийн газруудаас НИТХ-д өргөн барьж батлуулсан. Үүнд:<br>- *Дулааны тавдугаар цахилгаан станц,*<br>- *Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *Коп 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар*<br>- *Нийслэлийн авто тээврийн бүртгэл хэрэгслийн бүртгэл, хяналтын төв,*<br>- *Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв*<br>- *Урт цагаан үйлдвэрийн газар* | |
| 2.31 | Арга хэмжээ 2.31<br>Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", 65 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийсэн. Үүнд:<br><br>1.Удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн хяналт шалгалт:<br>- *2024.12.31-ний өдрийн А/798 дугаар тушаалаар нийслэлийн 6 дүүргийн 112 барилгын сул буюу илүүдэлтэй байр талбай, түрээсийн гэрээний хэрэгжилт,*<br>- *2025 оны А/40 дүгээр тушаалаар нийслэлийн 6 дүүргийн 201 барилга байгууламж, Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-дийн байр ашиглалт, түрээсийн гэрээний хэрэгжилт, төлбөр төлөлгүй нийслэлийн өмчийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг олж тогтоох, гэрээ байгуулахыг даалгах, байр талбайг чөлөөлүүлэх, түрээсийн төлбөрийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн эсэхийг газар дээр нь шалгаж, зөрчлийг арилгуулах,*<br>- *2025 оны А/62 удирдамжийн дагуу 6 дүүргийн ЗДТГ,ИХ, боловсролын нийт 215 байгууллагад газар дээр нь очиж үзэн, хяналт шалгалтыг хийж, түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа байр талбайд хяналтын хэмжилт хийх, барилгын дээвэр дээр үүрэн телефоны станц антен, байр талбайд бэлэн мөнгөний АТМ, киоск* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *машинуудыг байршуулсан эсэхэд хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ авах,*<br>- *2025 оны А/170 дугаар тушаалаар ЧД-ийн ЗДТГ болон төсөвт, орон нутгийн өмчит 7 хуулийн этгээдүүдийн нийт* 5,429,399,386.50 төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 92,737,492,228.88 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, 51 *балансад бүртгэлтэй барилга байгууламж, байр талбайн ашиглалт, түрээс, үл хөдлөх хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, түүнтэй холбоотой шийдвэрүүдэд хяналт шалгалт,*<br>- *2025 оны А/244, А/261, А/262 дугаар тушаалаар “Зорчигч тээвэр дөрөв”, “Зорчигч тээвэр нэг”, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-удын санхүү болон хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, зарцуулалтад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдалд санал дүгнэлт гаргах.*<br><br>2.Нийслэлийн өмчийн барилгын байр, талбайн ашиглалттай холбоотой :<br>- *Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн 4 байгууллагын байр ашиглалт, Ашигт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах МШ-ийн 24-р салбарын гар утасны түрээслэгчид, “Ачит гар” ӨЭМТ-д тус тус байр талбай чөлөөлөх мэдэгдэл хүргүүлсэн.*<br>- *СХД-ийн Цагдаагийн гуравдугаар хэлтэст “Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв”-ийн холбогдох баримт бичгийн хуулбар, лавлагааг нотлох баримтын шаардлагыг хангуулж хүргүүлсэн.*<br>- *Соёлын Төв өргөөний Г блокд байрлах нийслэлийн харьяа 6 байгууллага, 24 иргэн, аж ахуй нэгжийн 150 гаруй өрөө үйл ажиллагаа явуулж байснаас 30 иргэн аж ахуй нэгжид байр талбай чөлөөлөх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн,*<br>- *СБД-ийн 11 дүгээр хорооны Барилгачидын гудамжид барилгын хашаан дотор 2012, 2013 байршуулсан сурталчилгааны самбарын талаар хорооны ажилтан,* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилга барихаар төлөвлөсөн компаниас мэдээллийг авсан,<br>- "Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв"-ийн СХД-т байрлах эмнэлэг, ХУД-т байрлах "Богд уул" Сувилалын хөрөнгийг СХД-ийн Нэгдсэн эмнэлгийн баг бүрэлдэхүүнтэй хамтран газар дээр нь очиж, хөрөнгийг тоолж, хүлээлцүүлсэн.<br>- СТӨ-ны 8 дугаар давхрын 2 өрөө, Хүүхдийн номын сангийн 1 давхрын 1 өрөөг ашиглаж байсан "Сөүлийн соёл мэдээллийн төв"-ийн байр талбайг чөлөөлүүлэн, үйл ажиллагаандаа ашиглаж байсан гэх тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэх, ашиглах боломжгүй талаар НЗДТГ-т албан бичгийг хүргүүлсэн.<br>- "Таван толгой түлш" ХХК-д НӨХГ-ийн эзэмшил газарт шахмал түлшний агуулахын зориулалтаар баригдсан 59 саравчийг нийслэлийн өмчид бүртгэх, цаашид ашиглах боломжгүй, ашиглаж байсан газрын төлбөр тооцоог барагдуулан, газрыг чөлөөлж, манай байгууллагад хүлээлгэн өгөх тухай мэдэгдсэн,<br>- 9 дүүргийн харьяа нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилга байгууламжуудын судалгааг авч нэгтгэн, газрын даргад танилцуулсан.<br>- НӨХГ-ын даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг "Улаанбаатар радио" ХХК-ийн эзэмшиж байсан Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блокийн" барилгыг акт үйлдэн хүлээн авсан.<br>- Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн харьяа 4 байгууллагын байр ашиглалт, Ашигт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах Монгол шуудангийн 24-р салбарын гар утасны түрээслэгчид, Ачит гар ӨЭМТ-д байр талбай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлсэн.<br>- "Таван толгой түлш" ХХК-д НӨХГ-ийн эзэмшил газарт шахмал түлшний агуулахын зориулалтаар баригдсан 59 саравчийг нийслэлийн өмчид бүртгэх, цаашид ашиглах боломжгүй, ашиглаж байсан газрын төлбөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *тооцоог барагдуулан, газрыг чөлөөлж, манай байгууллагад хүлээлгэн өгөх тухай албан бичгийг хүргүүлсэн,*<br>- *9 дүүргийн харьяа нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилга байгууламжуудын судалгааг гаргасан,,*<br>- *НӨХГ-ын даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг “Улаанбаатар радио”ХХК-ийн эзэмшиж байсан Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн” барилгыг акт үйлдэн хүлээн авсан,*<br>- *Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн харьяа 4 байгууллагын байр ашиглалт, Ашигт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах Монгол шуудангийн 24-р салбар (хуучнаар)-ын байр, талбайд гар утасны түрээслэгчид, “Ачит гар” ӨЭМТ-д байр талбай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлсэн.* | |
| **Зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 3 | Зорилт 3. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна. | | | | | | |
| 3.1 | Арга хэмжээ 3.1<br>Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаж хяналт шинжилгээ үнэлгээ хийж НЗДТ-т тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | НЗДТГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу дараах төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>- *Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01,03,04 дугаар албан даалгавар хэрэгжүүлэх төлөвлөгөө (18 арга хэмжээ),*<br>- *Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2025 онд байгуулсан “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний төлөвлөгөө (25 арга хэмжээ),*<br>- *Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө,*<br>- *Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл.* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг НЗДТГ, ТӨБЗГ-т хугацаанд нь хүргүүлж тайлагнасан. Үүнд:<br>- *МУИХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний өөрийн байгууллага, 33 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тайланг ТӨЗБЗ-т;*<br>- *“Алсын хараа-2050” МУУХХБ-ын шалгуур үзүүлэлтийн 2015-2025 оны явцын тайлан мэдээ (7 ажил);*<br>- *МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;*<br>- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан (30 заалт);*<br>- *МУЕС-ын 2024 оны №1 албан даалгаврын төлөвлөгөөний биелэлт (6 арга хэмжээ);*<br>- *МУС, ЗГХЭГД-ын даргын НЗДБУХЗ-тай 2025 онд байгуулсан “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний биелэлт (22);*<br>- *МУЗГ-ын 2022-2024 оны тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын хэрэгжилт (6);*<br>- *МУЗГ-ын 2025.11.26-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт (10);*<br>- *Мэдээллийн ил тод байдлын 2024 оны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт (3);*<br>- *НИТХ-ын 2025 оны тогтоолын биелэлт (22);*<br>- *“Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний шалгуур үзүүлэлтийн тайлан (4);*<br>- *Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх ТЖҮЧ-д тусгах санал (4);*<br>- *Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Нийслэлийн хөгжлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 2025 оны үр дүн, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт;*<br>- *НЗДБУХЗ-ийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *НЗД-ын 2024 оны 1 болон 3 дугаар Албан даалгаврын хэрэгжилт (10);*<br>- *НЗД-ын 2024-2025 оны захирамжаар байгуулсан ажлын хэсгийн биелэлт;*<br>- *НЗД-ын 2025 оны А/61 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэгт байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн 2024 оны биелэлт;*<br>- *НЗДТГ-ын 2025 оны "Байгууллагын дотоод үнэлгээ зохион байгуулах тухай" ажлын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээний зөвлөмжийн тайлан;*<br>- *НЗД-ын захирамжаар байгуулсан 8 ажлын хэсгийн биелэлт (4 удаа);*<br>- *НЗД-ын 2025 оны захирамжийн биелэлт,*<br>- *НЗДЗ-ийн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт (19 шийдвэр);*<br><br>Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжаар байгуулсан ажлын хэсэгт орж санал, мэдээ хүргүүлэн ажилласан. Үүнд:<br>- *А/127 дугаар захирамжаар "Улаанбаатар радио" ХХК-тай холбоотой үүссэн асуудлыг судалж, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг,*<br>- *А/264 дүгээр захирамжаар "Нью тур сафарис" ХХК-ийн эзэмшиж байгаа Соёлын төв өргөөний "В" корпусыг нийслэлийн өмчид буцаан авах асуудлыг судалж хэлцэл хийх, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг,*<br>- *А/266 дугаар захирамжаар нийслэлийн өмчит "Дун өргөө" ХХК-ийн хувьцааг нийслэлийн өмчид шилжүүлэн авах асуудлаар хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах холбогдох саналыг боловсруулан танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг,*<br>- *А/307 дугаар захирамжаар байгуулсан "Улаанбаатар смарт карт" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ти мони" ХК-ийн нийслэлд шилжүүлэх 55 хувийн хувьцаанд ногдох биет болон биет бус хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсэг,* | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *А/363, А/372 дугаар захирамжаар байгуулсан СБДЗДТГ-ын хуучин байрыг буулгаж шинээр оффис үйлчилгээний барилга барих төсөл"-ийн онцгой эрх (концесс) олгох гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах, шаардлагатай тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах, шаардлагатай тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хэлэлцээ хийх, гэрээний төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг.* | |
| 3.2 | Арга хэмжээ 3.2 Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Ирүүлсэн зөвлөмжийн тоо, хэрэгжилтийн хувь | Нийслэлийн Төрийн аудитын зөвлөмж, НЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмж, 100% | 3<br>100% | Дээд байгууллагаас ирүүлсэн дараах зөвлөмж, чиглэлийг хэрэгжилтийг хангаж хугацаанд нь тайлагнан ажилласан. Үүнд:<br>- *НЗДТГ-ын 2025 оны 03/2113 дугаар албан бичгээр "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээ"-г байгууллага дотооддоо үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу НӨХГ-ын даргын 2025.04.22-ны өдрийн А/43 дугаар тушаалаар үнэлгээ зохион байгуулах ажлын хэсгийг нэгжийн удирдлагууд, холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсэг байгууллагын засаг төлөв байдлын үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэл цуглуулан, холбогдох баримтууд, мэдээллийг судалж дүн шинжилгээ хийн, судалгаа, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийн байдалд тулгуурлан www.moontra.com үнэлгээний цахим маягтад 2025.04.25-ны өдөр 126 асуумжийг хамтран хэлэлцэж бөглөсөн болно. Тайланг НЗДТГ-т 2025.04.25-ны өдрийн 1/665 дугаар албан бичгээр хүргүүлсэн.*<br>- *Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын "Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах тухай" 2025 оны 2025/01 дүгээр албан даалгаврын холбогдох заалтын биелэлтийг гаргаж НӨХГ-ын 2025.12.05-ны өдрийн 1/2245 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.*<br>- *ТӨБЗГ-ын 2025.05.19-ний өдрийн А-1/963 дугаар албан бичгээр ирүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн өөрийн болон орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 33 хуулийн* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *этгээдүүдийн мэдээллийг нэгтгэн НӨХГ-ын 2025.06.02-ны өдрийн 1/889 албан бичгээр хүргүүлсэн.*<br>- *НЗДТГ-ын "Ахмадын туршлага байгууллагын хөгжилд" хэлэлцүүлгийн зөвлөмж,*<br>- *НЗДТГ-ын Төрийн албын хэргийг хос бичгээр хөтлөн явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө,*<br>- *НЗДТГ-ын "ННЗБ-ын мэдээллийн системд чиглэсэн кибер хандлага, зөрчлийг ирүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах зөвлөмж,*<br>- *ХБҮЗАА-ны монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлыг эрчимжүүлэх хүрээнд байгууллагын удирдлагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж,*<br>- *НЗДТГ-ын ХШҮХ-ийн ажлын зөвлөмж "Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/62 захирамжийн хэрэгжилтийг хангах,*<br>- *МУБС-ын төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай зөвлөмж,*<br>- *НЗДТГ-ын ХШҮ-ний ажлын зөвлөмж "захирамжаар байгуулсан ажлын хэсэг болон НЗДТГ-ын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ"-ний зөвлөмж.*<br><br>НЗДТГ-аас ирүүлсэн журам, захирамж, үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэл, гэрээний төсөл зэрэг баримт бичгийг хяналтад авч нийт хэлтэст "танилцуулах", "санал авах" хуудас, ERP/НӨХГ-ын бүлэгт байршуулан үүрэгжүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 3.3 | Арга хэмжээ 3.3<br>НЗДТГ Монгол Улсын сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах | - | Ажил, үйлчилгээ, хөрөнгийн дүн, сая төг | - | 79 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" захирамжийн дагуу тээврийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа зохион байгуулж 2025.11.11-ний өдөр 28.5 сая төгрөгийн тендерийг зарласан. бөгөөд 2025.11.19-ны өдөр тендер нээхэд санал ирүүлээгүй байна.<br><br>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудаас зохион байгуулсан дараах худалдан авах ажиллагаанд гишүүнээр оролцож санал хүргүүлсэн. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнах | | | | | 1.Асгат ОНӨААТҮГ-ын "2025 оны БГД-ийн цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер":<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр нийт 27 багцтай 4,487,585,800 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр тендер нээж, давхацсан тоогоор 35 аж ахуй нэгж, хуулийн этгээд материалаа ирүүлсэн бөгөөд 14 багц шалгарсан байна.*<br>- *Дахин тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 04 дугаар сарын 18-ны өдөр 13 багцтай 2,849,382,700 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тендер нээж, давхацсан тоогоор 11 аж ахуй нэгж, хуулийн этгээд материалаа ирүүлсэн бөгөөд 2025 оны 06 дуугаар сарын 02-ны өдөр үр дүн нийтэлж 5 багц шалгарсан байна.*<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр 8 багцтай 4,487,585,800 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр тендер нээж, 27-Ахуйн барааны багц дээр 1 аж ахуй нэгж, хуулийн этгээд материалаа ирүүлсэн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр үр дүн нийтэлж багц шалгараагүй байна.*<br><br>2.Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын "2025 оны Сүхбаатар, чингэлтэй дүүргийн цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер":<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 33 багцтай 7,436,780,950 төгрөгийн тендерийг зарласан 23 багцад 16 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлснээс 6 аж ахуйн нэгж 13 багцад гэрээ байгуулах эрх олгосон байна.* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *Дахин 2025.07.07-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны худалдан авах 15 багцад 1 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлснээс 3 багцад гэрээ байгуулах эрх олгосон байна.*<br>- *Дахин 2025.09.08-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны худалдан авах 12 багцад 1 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлснээс 7 багцад гэрээ байгуулах эрх олгосон байна.*<br><br>3."Улаанбаатар түншлэл төв" ХХК-ын "2025 оны Засвар үйлчилгээ сонгон шалгаруулах тендер" :<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 08 дугаар сарын 04-ны өдөр 350,000,00 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр тендер нээж, 2 аж ахуй нэгж, хуулийн этгээд материалаа ирүүлсэн бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр үр дүн нийтэлсэн байна.* | |
